



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/4/СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
(Дорноговь аймаг Сайншанд сум)  
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа  
Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn  
Аудитын менежерийн үүргийг  
түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг  
Утас: 70523020 Цахим хаяг: injig78@yahoo.com  
Аудитор: Ц.Энхтуяа  
Утас: 99042645 Цахим  
хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                                |
|----------|----------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын<br>Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                  |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                    |

## Агуулга

---

|         |                                                                                                               |                                     |
|---------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|
| 1       | Аудитын гэрчилгээ .....                                                                                       | 3                                   |
| 2       | Аудитын тайлан .....                                                                                          | 5                                   |
| 2.1.    | Оршил .....                                                                                                   | 5                                   |
| 2.2.    | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                         | 5                                   |
| 2.3.    | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                        | 6                                   |
| 2.4.    | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....                                               | 6                                   |
| 2.5.    | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6                                   |
| 2.6.    | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....                                         | 6                                   |
| 2.7.    | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....                                                     | 7                                   |
| 2.8.    | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....                                                    | 7                                   |
| 2.8.1   | Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....            | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.8.2   | Төсвийн шууд захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....                     | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.8.2.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....                                   | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.9.    | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.10.   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                                                         | 7                                   |
| 2.11.   | Шилэн дансны мэдээлэл .....                                                                                   | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.12.   | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....                                                 | 8                                   |
| 2.13.   | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....                                            | 9                                   |
| 2.14    | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....                                                                       | 9                                   |
| 3       | Менежментийн захидал .....                                                                                    | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 4       | Аудит хийсэн санхүүгийн тайлан .....                                                                          | 12                                  |

---

## 1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

2020.02.28 № 1-6/154  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-гийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-гийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.




Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Дорноговь аймгийн Халамж үйлчилгээний газрын дарга Д.Цэндмаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй үр нөлөөтэй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 сарын 06-ны өдрөөс 2020 оны 02 сарын 11-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 сарын 11 өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 24-ны өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## **2.3. Аудитын мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-гийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай орлоготой болгох, ядуурлыг бууруулж Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй болно.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Халамжийн сангийн /Орон нутгийн төсвөөс санхүүжих/ мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Finance, Wais, НЭВ программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд

байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн *Нийт зардлыг* сонгож, эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувийг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 114,888.0 мянган төгрөгөөс тооцон 2,297.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үеийн шатанд материаллаг байдлын түвшинг 2,297.8 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос өөрчлөгдөөгүй.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                              | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт |
|-------------------------------------------------------|-------------------|--------------------|----------|
| Б                                                     | 1                 | 2                  | 3=2-1    |
| <b>Нийт хөрөнгө</b>                                   |                   |                    |          |
| Өр төлбөр                                             | 5200.0            | 0                  | -5200.0  |
| Засгийн газрын оролцоо<br>/Эздийн өмч/                | -5200.0           | 0                  | 5200.0   |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр<br/>хөрөнгө өмчийн дүн</b> |                   |                    |          |

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны өрийг 2019 оны төсвөөс барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 5200.0 мянган төгрөгөөр өссөн нь дээрх шалтгаантай адил байна.

Тайлант онд 5,200.0 мянган төгрөгийн ашигтай ажилласантай холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ



хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Халамжийн сангийн 3 хөтөлбөрт зориулан 119800,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 119800,0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 119800,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийн 119800,0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого авсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлээр Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийн зардалд 95126.7 мөнгөн төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 91600.0 мянган төгрөг, Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөд 5200.0 мөнгөн төгрөг төлөвлөж 5200.0 мянган төгрөг зарцуулж, ОНОТХаламжийн үйлчилгээний зардалд 19473.3 мөнгөн төгрөг төлөвлөж 18990.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 115,790.0 мянган төгрөг буюу 97,94 хувьтай байгаа нь халамжийн сангаас 3526,7 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс 483.3 мянган төгрөг хэмнэснээс шалтгаалжээ..

Үүнээс зарцуулагдаагүй үлдэгдэл 4,298.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9498.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 9498.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 9498.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 44 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулаагүй байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 445,538.2 мянган төгрөгийн зөрчилд 0 төлбөрийн акт тогтоосноос 0 мянган төгрөгийг барагдуулсан, 0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 0 албан шаардлага хүргүүлснээс 0 мянган төгрөгийн ..... албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 0 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийг 0 хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/ нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүй хийж оны эцэст 4,298.0 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлэлт хийсэн байна.
2. Өмнөх онд төвлөрүүлсэн орлогоос 5,200.0 мянган төгрөг авлагаар бүртгэж тайлагнахыг орхигдуулснаас тайлант онд зардалд бүртгэж ашиг бууруулсан
3. Нягтлан бодох бүртгэлийн програм нь Сангийн яамнаас тавьсан шаардлагыг хангахгүй `staus.audit.mn` програмтай уялдахгүй байна.

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

### **3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл холбоотой асуудал**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Төсвийн төлөвлөлт хийхдээ өмнөх 3 жилийн судалгааг үндэслэж хийдэггүй өндөр төлөвлөж, тайлант оны эцэст 4,298.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг эргүүлэн төвлөрүүлсэн байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг зөрчсөн байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хэтрүүлэн зарцуулсан байх

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн төлөвлөлтийг өмнөх 3-5 жилийн судалгааг үндэслэн бодиттой хийх

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжтэй танилцсан, хэрэгжүүлж ажиллана

### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Өмнөх онд төвлөрүүлсэн орлогоос 5,200.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнахыг орхигдуулснаас тайлант онд зардалд бүртгэж ашиг бууруулсан

Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 заалтыг зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Мөнгөн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн ажил гүйлгээг гарсан тухай бүр нь бүртгэн, тайлагнаж байх

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжтэй танилцсан хэрэгжүүлж ажиллана

## 3.3 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

### 3.3.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн програм нь Сангийн яамнаас тавьсан шаардлагыг хангахгүй status.audit.mn програмтай уялдахгүй байна.

Энэ нь оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчиж байна.

### 3.3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж Сангийн яамнаас тогтоосон шаардлагыг хангаагүй байх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн яамнаас тавьсан шаардлага хангасан програм ашиглах

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжтэй танилцсан хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 03 сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийсэн санхүүгийн тайлан

**4.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт                           | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---------------------------------------------|----------------|-----------------|
| 3          | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II                 | <u>0.00</u>    | <u>0.00</u>     |
| 41         | Богино хугацаат өр төлбөр                   | 5,200,000.00   | 0.00            |
| 41.1       | Өглөг                                       | 5,200,000.00   |                 |
| 410105     | Байгууллагад өгөх ОНТ-ийн өглөг             | 5,200,000.00   |                 |
| 41         | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН            | 5,200,000.00   |                 |
| 51         | Хуримтлагдсан үр дүн                        | (5,200,000.00) | 0.00            |
| 510301     | Өмнөх үеийн үр дүн                          | (5,200,000.00) |                 |
| 5103010002 | Өмнөх үеийн үр дүн орон нутаг               | (5,200,000.00) |                 |
|            | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>0.00</u>    | <u>0.00</u>     |

**4.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт                                                              | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|-----------------------------------------------------------------------|---------------------|-----------------------|
| 1303       | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО                                           | 5,483,048,400.00    | 119,800,000.00        |
| 130302     | Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого                             | 5,483,048,400.00    | 119,800,000.00        |
| 14120      | Бараа үйлчилгээний орлого                                             | 16,240,152.24       | 288,048.11            |
| 1401021    | Орон нутгийн төсвийн хүүгийн орлого                                   | 16,240,152.24       | 288,048.11            |
| 1          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН                                           | 5,499,288,552.24    | 120,088,048.11        |
| 2603       | Төсөвт төвлөрүүлэх                                                    | 379,382,248.24      | 4,298,048.11          |
| 260302     | Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв                                 | 379,382,248.24      | 4,298,48.11           |
| 2701+2702  | НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ                                  | 5,121,017,454.00    | 110,590,000.00        |
| 2701021100 | Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт                               | 2,322,330,000.00    |                       |
| 2701021200 | Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт                               | 774,195,960.00      |                       |
| 2701021300 | Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт | 653,111,920.00      | 91,600,000.00         |
| 2701021500 | Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт     | 457,779,599.00      |                       |
| 2701021604 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт                       | 194,509,580.00      |                       |
| 2701022000 | Жирэмсэн, нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт         | 259,552,910.00      |                       |

|            |                                                        |                    |                   |
|------------|--------------------------------------------------------|--------------------|-------------------|
| 2701023000 | ОНОТүшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт        | 18,067,500.00      | 18,990,000.00     |
| 2701024000 | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт | 303,356,550.00     |                   |
| 2702020306 | Үйл ажиллагааны зардал                                 | 1,828,295.00       |                   |
| 2702020307 | Үйл ажиллагааны зардал /судалгаа/                      | 2.335,100.00       |                   |
| 2702020308 | Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал        | 8,781,800.00       |                   |
|            | Банкны шимтгэл                                         | 4,088,850.00       |                   |
| 213304     | Банкны шимтгэл ОНТөсөв                                 | 4,088,850.00       |                   |
|            | Банкны шимтгэл Халамжийн сан                           | 4,088,850.00       |                   |
|            | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                     | 5,504,488,552.23   | 114,888,048.11    |
| 3          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (</b>                   | <b>-5200000.00</b> | <b>5200000.00</b> |

#### 4.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт                                                                     | /Төгрөгөөр/             |                       |
|------------|------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------|
|            |                                                                              | Өмнөх оны гүйцэтгэл     | Тайлант оны гүйцэтгэл |
| 1303       | <b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                          | <b>5,483,048,400.00</b> | <b>119,800,000.00</b> |
| 130302     | <b>Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого</b>                             | <b>5,483,048,400.00</b> | <b>119,800,000.00</b> |
| 14120      | <b>Бараа үйлчилгээний орлого</b>                                             | 28,053,553.24           | 288,048.11            |
| 1401021    | Орон нутгийн төсвийн хүүгийн орлого                                          | 16,240,152.24           | 288,048.11            |
| 1401023    | Орон нутгийн төсвийн буцаасан орлого                                         | 11,813,401.00           |                       |
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ</b>                                    | <b>5,511,101,953.24</b> | <b>120,088,048.11</b> |
| 2701+2702  | <b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ</b>                                  | <b>5,127,470,855.00</b> | 115,790,000.00        |
| 2701021100 | Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт                                      | 2,322,330,000.00        |                       |
| 2701021200 | Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт                                      | 774,195,960.00          |                       |
| 2701021300 | <b>Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт</b> | 653,111,920.00          | 91,600,000.00         |
| 2701021500 | Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт            | 456,046,900.00          | 5,200,000.00          |
| 2701021604 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт                              | 194,509,580.00          |                       |
| 2701022000 | <b>Жирэмсэн, нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт</b>         | 259,516,800.00          |                       |
| 2701023000 | ОНОТүшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт                              | 18,067,500.00           | 18,990,000.00         |
| 2701024000 | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт                       | 436,747,000.00          |                       |
| 2702020306 | Үйл ажиллагааны зардал                                                       | 1,828,295.00            |                       |
| 2702020307 | Үйл ажиллагааны зардал /судалгаа/                                            | 2.335,100.00            |                       |

Дорноговь аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсвөөс санхүүжих/«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|            |                                                            |                         |                |
|------------|------------------------------------------------------------|-------------------------|----------------|
| 2702020308 | Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал            | 8,781,800.00            |                |
|            | Банкны шимтгэл                                             | 4,088,850.00            |                |
| 213304     | Банкны шимтгэл ОНТөсөв                                     | 4,088,850.00            |                |
|            | Банкны шимтгэл Халамжийн сан                               | 4,088,850.00            |                |
|            | Өмнөх оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт                  | 160,000.00              |                |
|            | Өмнөх оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт ОНТөсөв          | 160,000.00              |                |
|            | <b>Төсөвт төвлөрүүлэх</b>                                  | 379,382,248.24          | 4,298,048.11   |
|            | Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв                      | 379,382,248.24          | 4,298,048.11   |
|            | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>                  | 5,511,101,953.23        | 120,088,048.11 |
|            | Сангийн үйл ажиллагааны зардал                             | 5,119,906,304.00        |                |
|            | Насны хишиг                                                |                         |                |
|            | Халамжийн сан                                              | 4,405,508,859.00        |                |
|            | Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж | 259,552,910.00          |                |
|            | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ      | 18,067,500.00           |                |
|            | Хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөрийн зардал          | 428,524,790             |                |
|            | Банкны шимтгэл                                             | 4,088,850.00            |                |
| 3          | Сангийн үйл ажиллагааны зардлын дүн                        | <b>4,163,395.00</b>     |                |
| 1303       | <b>УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ</b>                            | <b>5,131,719,705.00</b> |                |
| 213203     | Тохируулгын дүн                                            | 11,813,401.00           |                |
| 2133       | <b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>                    |                         |                |

#### 4.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт                                | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээн ий нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|-----------------------------------------|---------------------------------|------------------------|-------------------|-------|----------------------------------------|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл   |                                 |                        | -5,200,000.00     |       | -<br>5,200,000.00                      |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл              | 0.00                            | 0.00                   | -5,200,000.00     | 0.00  | -<br>5,200,000.00                      |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт |                                 |                        |                   |       | 0.00                                   |

|     |                                       |      |      |               |      |                   |
|-----|---------------------------------------|------|------|---------------|------|-------------------|
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | -5,200,000.00 | 0.00 | -<br>5,200,000.00 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | -5,200,000.00 | 0.00 | -<br>5,200,000.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 0.00 | 0.00 | -5,200,000.00 | 0.00 | -<br>5,200,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  |      |      | 5,200,000.00  |      | 5,200,000.00      |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00          | 0.00 | 0.00              |

#### 4.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт                                               | Өмнөх оны             |                  | Тайлант оны           |                |
|-----------------------|--------------------------------------------------------|-----------------------|------------------|-----------------------|----------------|
|                       |                                                        | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл        | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл       |                       |                  |                       |                |
| 2                     | Сангийн үйл ажиллагааны зардал                         | 5,483,048,400.00      | 5,119,906,304.00 | 119,800,000.00        | 115,790,000.00 |
| 3                     | Халамжийн сан                                          | 4,593,505,000.00      | 4,405,508,859.00 | 95,126,700.00         | 91,600,000.00  |
| 4                     | Жирэмсэн, нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж | 288,000,000.00        | 259,552,910.00   |                       |                |
| 5                     | Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ   | 20,000,000.00         | 18,067,500.00    | 19,473,300.00         | 18,990,000.00  |
| 6                     | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт | 569,952,000.00        | 428,524,790.00   |                       |                |
| 7                     | Банкны шимтгэл                                         | 6,633,000.00          | 4,088,850.00     |                       |                |
| 8                     | Сангийн үйл ажиллагааны зардлын дүн                    | 4,958,400.00          | 4,163,395.00     |                       |                |
| 9                     | ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ                        |                       | 5,131,719,705    | 119,800,000.00        | 115,790,000.00 |
| 10                    | Тохируулга                                             |                       | 11,813,401.00    |                       |                |
| 11                    | Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал              |                       |                  | 5,200,000.00          | 5,200,000.00   |